


БАТЛАВ.
ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Д.БАТ-УНДРАХ
2025 ОН 12 САР 23 ӨДӨР

Удирдлагын зөвлөлийн 2025 оны 12 сарын 23-ны өдрийн
хурлаар хэлэлцэх асуудлын хөтөлбөр

№	Хэлэлцэх асуудал	Хариуцах албан тушаалтан
1.	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт үнэлгээний танилцуулга	Стратги төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн Л.Халиун
2.	Байгууллагын 2025 оны шилдэг эмч, сувилагч, мэргэжилтэн, ажилтанд нэр дэмшиж байгаа ажилтнуудын танилцуулга	Албаны дарга нар
3.	Мэдээллийн технологийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар танилцуулга	Мэдээллийн технологийн инженер П.Ганзориг
4.	Магадлангийн бэлтгэл ажлын танилцуулга, цаашид авах арга хэмжээний талаар танилцуулга	ЭМТҮЧАБА-ны дарга Э.Наранхүү
5	Сэргээн засал судлалын их эмч Ч.Загарсүрэн туршилтын хугацаанд хийсэн ажлын танилцуулга	Хүний нөөцийн менежер Ч.Өнөрцэцэг
4	Хурлын дүгнэлт хаалт	Захирал Д.Бат-Ундрах

БОЛОВСРУУЛСАН:
СТРАТЕГИ, ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЛБАНЫ ДАРГА  Н.ДӨЛГОРМАА

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

2025.12.23

Төвийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/101 тоот тушаалаар батлагдсан хяналт үнэлгээний баг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалыг үндэслэн Геронтологийн Үндэсний төвийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийлээ.

2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт үнэлгээ хийхэд нийт 11 зорилтын хүрээнд 36 арга хэмжээ хэрэгжүүлэх байснаас бүрэн хэрэгжсэн 29 ажил, хэрэгжих шатны 5 ажил, хэрэгжилт хангалтгүй 1, хэрэгжээгүй 1 ажил байна.

Хэрэгжээгүй 1 ажил: Энэ нь шинээр тусламж үйлчилгээ нэвтрүүлж өртөг зардлыг тооцох ажлыг 2024, 2025 онд дараалан төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй

Хэрэгжилт хангалтгүй 1 ажил:

- Тухайн оны төсөвт суугаагүй ажлыг бүрэн хэрэгжүүлнэ гэж тусгаснаас Настны эрүүл мэнд, нийгэм сэтгэл зүйн байдлын үндэсний хэмжээний тойм судалгааны ажил хийх нөхцөл бүрдээгүй

Хэрэгжих шатны 6 ажил:

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээнд настныг хамруулж буй настнуудын байгууллага, иргэн, аж ахуйн нэгжид ажиллаж буй мэргэжилтэнг мэргэшүүлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах
- Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах
- Чанарын олон улсын удирдлагын тогтолцооны сайн туршлага судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах
- Төвийн хөдөлмөрийн дотоод журам, ажлын үнэлгээний журмуудыг шинэчлэх
- Насжилт, настны эрүүл мэнд сэтгүүлийг эрхлэн гаргах зэрэг ажлууд

Хэрэгжилт хангалттай – 29 ажил

Бусад:

- Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 1 ч ажил төлөвлөгөөнд тусгагдаагүй

Үнэлгээний дүн алба нэгжээр:

№	Алба	Хариуцсан ажлын тоо	Биелэлтийн хувь	Хяналт үнэлгээний хувь
1	ЗТСХА	21	95.9%	94.28%
2	ЭТҮА	5	100%	95%
3	ЭМТҮЧАБА	4	100%	92%
4	СБДҮА	6	99.16%	80.83%
Нийлбэр		36	98.7%	90.52%

Зөвлөмж:

- Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг 2026 оны төлөвлөгөөнд тусгах, үр дүнг тооцох,
- Чанарын сайн туршлага нэвтрүүлж, үр дүнг тооцох ажилд онцгой анхаарах,
- Ахмад настны цогц тусламж үйлчилгээний заавар, журмын дагуу 2,3-р түвшиний настаны эмчилгээ, зөвлөгөөний үр дүнг хянах, эргэх холбоог сайжруулах ажлыг 2026 онд хэрэгжүүлэх,
- Ахмад настан, гэр бүл, асран хамгаалагчид, үйлчилгээ үзүүлэгчдэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлын нэр төрлийг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх ажиллагааг 2026 онд бодитойгоор төлөвлөж хэрэгжүүлэх,
- Ахмад настны хам шинжийг илрүүлэх цогц үнэлгээний сургагч багшийн тоог нэмэгдүүлэх, анхан шатны эрүүл мэндийн болон халамж үйлчилгээний байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдийг арга зүйгээр хангах ажлын хүртээмжийг сайжруулах
- Шинээр нэвтрүүлэх тусламж үйлчилгээний өртөг зардлыг тооцох ажлыг 2024, 2025 онд дараалан төлөвлөсөн боловч огт хэрэгжүүлээгүй байгаад дүгнэлт өгч, төлөвлөлтийг бодитой хийх
- Төсвийн төсөлд санхүүжилт нь тусгагдаагүй томоохон ажлыг бүрэн хэрэгжих боломжтой эсэхийг судалж төлөвлөгөөнд тусгах

ЗТСХА-НЫ ДАРГА

БАГИЙН АХЛАГЧ:

Н.ДОЛГОРМАА

ЭМТҮЧАБА-НЫ ДАРГА

ГИШҮҮД:

Г.НАРАНХҮҮ

СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Л.ХАЛИУН

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

- Хуралд оролцсон гишүүд 100 % ийн саналаар үргэлжлүүлэн ажиллуулахыг дэмжсэн Сэргээн засах судлалын их эмч Ч.Загарсүрэнгийн Хөдөлмөрийн гэрээг сунгах,
- Магадлан итгэмжлэлийн бэлтгэл ажил хангахтай холбоотойгоор шаардлагатай жижиг хэрэгсэл, стандарт худалдан авах асуудлыг Санхүү бүртгэл, аж ахуйн албаны дарга, Эдийн засагч нар судалж, зохицуулалтыг хийх,
- Цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах асуудлаар үйлчилгээний 2 ажилтанг Санхүү бүртгэл, аж ахуйн албаны хурлаар хэлэлцэж, шийдвэрийг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулах,
- Мэдээллийн технологийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зардлын тооцоог нарийвчлан гаргаж, 2026 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд томоохон ажлуудыг тусгаж, хэрэгжилтийг хангах
- Удирдлагын зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар дэмжигдэж, 2025 оны шилдэгээр шалгарсан Шилдэг их эмч Н.Оюунтуяа, Шилдэг сувилагч И.Аззаяа, Шилдэг мэргэжилтэн С.Гантуяа, Шилдэг ажилтан М.Доржсэнгэ нарыг нэг сарын үндсэн цалингаар урамшуулах,
- Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт шинжилгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Албадын дарга, зөвлөлийн гишүүдэд үүрэг болгох

Хурал 2025 оны 12 дугаарын 23-ны өдрийн 15.30 минутанд өндөрлөв.

ЗАХИРАЛ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

ХУРАЛ УДИРДСАН:
Д.БАТ-УНДРАХ
Ц.БАЙГАЛЬМАА

ТАНИЛЦСАН:

ЗТСХА-НЫ ДАРГА Н.ДОЛГОРМАА
ЭТҮА-НЫ ДАРГА А.БАЙГАЛЬМАА
ЭМТҮЧАБА-НЫ ДАРГА Э.НАРАНХҮҮ
СБДҮА-НЫ ДАРГА Г.БАТБОЛД
АХЛАХ СУВИЛАГЧ М.ОТГОН ЖАРГАЛ
ҮЭ-ИЙН ДАРГА Ц.БАЯРМАА